



Аудитын код: САГ-2017/34/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261205 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Л.Хонгорзул

Утас: 261205 Цахим хаяг: khongorzull@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл.....	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.5	Дотоод хяналт.....	6
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар.....	7
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	9
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	11
3.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
3.2	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
3.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
3.4	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

1. Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 768

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0425SAG40.Docx

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хүний хөгжил сангийн төсвийн ерөнхийлөн захирагч, Монгол Улсын Сангийн сайд Б.Чойжилсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуулан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Л.Хонгорзул хариуцаж хэрэгжүүлэв.

Сангийн сайд 2016 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 12-1/1892 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүний хөгжил сангийн тухай хууль 2009 онд батлагдсан бөгөөд ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, иргэддээ тэгш хүртээх зорилгоор Хүний хөгжил санг байгуулсан байна.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “...*ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулах, түүнийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавих...*” гэж хүний хөгжил сангийн зорилго, чиг үүргийг заасан байна.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дугаар зүйлүүдэд заасан үндэслэл шаардлагын дагуу Хүний хөгжил сангийн 2016 оны санхүүгийн тайланг гаргасан байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “*Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна*” мөн хуулийн 14.1.8-д “*Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн*” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Сангийн сайд Хүний хөгжил сангийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас санхүүжилтийн эрх олгосноор Засгийн газрын бондын төлбөр, тайлант оны эхний 6 сард 0-18 насны хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөг, 7 дугаар сараас зорилтот бүлгийн хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөгийн санхүүжилт зэрэг хуулиар тогтоосон сангийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд тус сан нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүний хөгжил сангийн үйл ажиллагааны талаар /ТАБ-СТА-А-1/ маягтад тодорхой тусгасан.

Хүний хөгжил сангийн төсвийн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай, Хүний хөгжил сангийн тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдах болсноор 2016 онд УИХ-аас Хүний хөгжил сангийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль баталж, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцохоор болсон байна.

Мөн УИХ-ын 2016 оны 38 дугаар тогтоолоор “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2015 оны 103 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр олгох 20.0 мянган төгрөгийг 2016 оны 1-6 дугаар сард хүүхэд бүрд, 7-12 саруудад амьжиргааны түвшний 1-10 дугаар бүлэгт орсон хүүхэд бүрд бэлэн мөнгөөр, үлдэх хүүхдэд олгох мөнгийг хойшлуулан 2019 оноос эхлэн нөхөж олгохоор шийдвэрлэсэн байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Хүний хөгжил сангийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 2 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 3 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хүний хөгжил сан нь “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн PTreasury програм ашигладаг бөгөөд Сангийн сайдын 2005 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан *“Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”*-ын дагуу “Plastic” програмыг ашиглан төсвийн багцын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хүний хөгжил сангийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хүний хөгжил сангийн санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Хүний хөгжил сангийн үйл ажиллагаа, төрийн сангийн төлбөр тооцоо, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд Сангийн яамны ДАХШҮГ-аас хяналт тавьж дүгнэлт зөвлөмж өгч ажилласан байна.

Сангийн яамны ДАХШҮГ нь төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн тайлан, Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, байгууллагын үйл

ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар

Хүний хөгжил сангийн 2016 оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хүний хөгжил сангийн санхүүгийн тайлангаар урсгал зардалд 283.866.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 193,789.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 90,077.5 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Энэ нь 2016 оны хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Хүний хөгжил сангийн 2016 оны Төсвийн тухай хуулиар Хүний хөгжил сангийн төсвөөс 2016 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 283,866.9 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 1,021.078 хүүхдэд нийт 218,828.8 сая төгрөг олгож, үнэт цаасны хүүгийн төлбөрт 59,768.1 сая төгрөг төлж, нийт 278,596.7 сая төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг тайлант он болон өмнөх онтой харьцуулан дор нэгтгэн харуулав.

/сая төг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	2015 ОН		2016 ОН	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	328,792.8	308,374.8	283,867.0	278,596.7
1.1	Урсгал зардал	328,792.8	305,040.1	283,867.0	278,596.7
1.1.2	Хүү	67,415.4	67,290.0	60,667.0	59,768.1
	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	67,415.4	67,290.0	60,667.0	59,768.1
1.2.3	Урсгал шилжүүлэг	258,040.2	237,749.8	223,200.0	218,828.6
	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	258,040.2	237,749.8	223,200.0	218,828.6
1.2.4	Хөрөнгийн зардал		3,334.7		
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	356,932.3	423,029.8	283,867.0	193,789.4
2.1	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	286,932.3	423,029.8	283,867.0	193,789.4
2.2	Ноогдол ашиг	70,000.0			
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		33,575.5		84,807.3

2.7 Шилэн дансны мэдээлэл

Сангийн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг "shilendans.gov.mn" цахим хуудсаар дамжуулан Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага гэсэн тусгай цэсэнд, ХХҮЕГ нь Хүний хөгжил сангийн шилэн дансны мэдээллийг <http://hudulmur-halamj.gov.mn/> цахим хуудасны шилэн данс цонхонд Хүний хөгжлийн сан гэсэн тусгай цэсэнд тус тус мэдээлж ирсэн байна.

Гэвч Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой аудитаар илэрсэн зөрчил дутагдлын талаар асуудлын бүртгэлээр танилцуулж, энэ тайлангийн 2.9 дэх “Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал” хэсэгт тодорхой тусгасан болно.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Хүний хөгжил сангийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлд хийх аудитын төлөвлөлтийн шатанд 3 дансанд 6 эрсдэл агуулж байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар тулган баталгаажуулах, ажиглах, харьцуулах зэрэг сорил гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 10, тайлагналын үе шатыг 7 ажилбараар тус тус гүйцэтгэж аудитын менежер, газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудиторроор хянууллаа.

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 4 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага, өр төлбөр зэрэг дансдыг шалгаж баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/ Тухайлбал:

Тайлант онд Хүний хөгжил сангийн авлагын дүн АМНАТ-ын суутган тооцоогоор 16,364.2 сая, өглөгийн дүн УИХ-ын 2016 оны 38 дугаар тогтоолоор хүүхдийн мөнгийг амьжиргааны түвшинтэй уялдуулан 10 дугаар бүлгээс хойш орсон хүүхэд бүрд 2019 онд нөхөж олгохоор шийдвэрлэснээс 110,911.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Сангийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар Хүний хөгжил санд хуримтлагдсан өрийн жагсаалтыг баталж, өрийг улсын төсөвт шилжүүлэн бүртгэж улсын төсвөөс төлөх, тухайн шилжүүлсэн дүнгээр Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэн тус сангаас төлүүлэхээр, Хүний хөгжил сангийн тухай хуулийг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүйд тооцсонтой холбогдуулан Хүний хөгжил сангийн санхүүгийн тайланг хааж, Ирээдүйн өв сангийн санхүүгийн тайланг нээхээр шийдвэрлэсэн байна.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хүний хөгжил сан нь Шилэн дансны мэдээллийн сангийн төсөв/гүйцэтгэл цэсэнд нийт 5 төрлийн мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг, бусад цэсэнд байршуулах 1 мэдээллийг, Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын Хүний хөгжил сан нь Шилэн дансны мэдээллийн сангийн төсөв/гүйцэтгэл цэсэнд байршуулах 9 мэдээллээс 4-ийг, бусад цэсэнд байршуулах 6 мэдээллээс 5-ыг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн холбогдох заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хүний хөгжил сангийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын Хүний хөгжил сан” 2016 оны санхүүгийн тайланд холбогдох хуулийн дагуу аудит хийгдээгүй санхүүгийн тайлан нэгтгүүлсэн байна.

Хүний хөгжил сангийн авлага, өглөгийн тооцоо, үлдэгдлийг тулгаж холбогдох газруудтай тулгалт хийж амжаагүй бөгөөд Сангийн сайдын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны 2 дугаар сарын 15- ны өдрийн 58 дугаар тушаалаар Хүний хөгжил сангийн тайлангаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэх өрийн жагсаалтыг үндэслэн баталгаажуулав.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Хүний хөгжил сангийн тухай хууль нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болж тус сан нь татан буугдаж байгаа тул дараагийн аудитаар авч үзэх асуудал үгүй болно.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хүний хөгжил сан нь Шилэн дансны мэдээллийн сангийн төсөв/гүйцэтгэл цэсэнд нийт 5 төрлийн мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг, бусад цэсэнд байршуулах 1 мэдээлэлийг, Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын Хүний хөгжил сан нь Шилэн дансны мэдээллийн сангийн төсөв/гүйцэтгэл цэсэнд байршуулах 9 мэдээллээс 4-ийг, бусад цэсэнд байршуулах 6 мэдээллээс 5-ыг байршуулаагүй алдаа, зөрчил илэрснийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүний хөгжил сангийн төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газрын аудитор Г.Жавхлан аудит хийж, Хүний хөгжил санд 3 зөвлөмж өгснөөс өглөгийг бууруулах ажлыг зохион байгуулж ажиллах гэсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газарт өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 12-1/6610 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлжээ. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Хүний хөгжил сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 302,904.2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувиар тооцож 6,058.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүний хөгжил сангийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ДАНС НЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>236,258,590.9</u>	<u>-</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	84,807,303.0	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	84,807,303.0	-
3121	Төгрөг	54,867,603.0	-
31212	Монгол банкин дахь харилцах	54,867,603.0	
3122	Гадаад валют	29,939,700.0	-
31222	Монгол банк дахь харилцах	29,939,700.0	
33	АВЛАГА	151,451,287.9	-
335	Бусад авлага	151,451,287.9	-
3351	Байгууллагаас авах авлага	151,451,287.9	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>236,258,591.0</u>	<u>-</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,128,795,666.2</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,128,795,666.2	-
411	Богино хугацаат үнэт цаас	485,035,192.3	-
4111	Төгрөг	227,000,000.0	-
41111	Бонд	227,000,000.0	.
4112	Гадаад валют	258,035,192.3	-
41121	Бонд	259,477,400.0	-
41123	Бондын хөнгөлөлт	(1,442,207.7)	-
413	Өглөг	590,247,986.8	-
4136	Бусад өглөг	590,247,986.8	-
41361	Байгууллагад төлөх өглөг	569,974,166.8	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	20,273,820.0	-
414	Урьдчилж орсон орлого	53,512,487.1	-
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	34,965,223.3	-
41440	Бусад урьдчилж орсон орлого	18,547,263.9	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>(892,537,075.3)</u>	<u>-</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	892,537,075.3)	-
512	Хуримтлагдсан үр дүн	(892,537,075.3)	-
51210	Өмнөх үеийн үр дүн	982,525,377.6)	179,354,284.5
51220	Тайлант үеийн үр дүн	89,988,302.4	(179,354,284.5)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>236,258,590.9</u>	<u>-</u>

Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	423,052,752.0	187,677,198.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	423,029,798.9	187,664,155.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	423,029,798.9	187,664,155.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	423,029,798.9	187,664,155.9
118004	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	423,029,798.9	187,664,155.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,375.3	-
120	Нийтлэг татварын бус орлого	6,375.3	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,375.3	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,375.3	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,577.8	13,042.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,577.8	13,042.7
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,577.8	13,042.7
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	309,627,449.1	302,904,190.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,292,757.3	302,904,190.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	243.0	8.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243.0	8.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	243.0	8.0
211	ХҮҮ	48,252,314.3	54,913,202.2
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	48,252,314.3	54,913,202.2
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	48,252,314.3	54,913,202.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,040,200.0	247,990,980.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	258,040,200.0	247,990,980.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	246,000,000.0	247,990,980.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,040,200.0	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,334,691.8	-
2200	Дотоод эх үүсвэрээр	3,334,691.8	-
220001	Барилга байгууламж	3,334,691.8	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	113,425,302.9	(115,226,991.7)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,437,000.5	64,127,292.9
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	23,437,000.5	64,127,292.9
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(23,437,000.5)	(64,127,292.9)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	89,988,302.4	(179,354,284.5)

3.2 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	/мян.төг/	
				ХУРИМТЛАГДСАН ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН
C01	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	0.00		-530,292,899.8	-530,292,899.8
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-452,232,477.8	-452,232,477.8
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-982,525,377.6	-982,525,377.6
C07	Тайлант үеийн үр дүн			89,988,302.4	89,988,302.4
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-892,537,075.3	-892,537,075.3
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-892,537,075.3	
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	-892,537,075.3	-892,537,075.3
D08	Тайлант үеийн үр дүн			-179,354,284.5	-179,354,284.5
D09	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ДАНСН Ы КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>606,677,949.5</u>	<u>171,312,986.0</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	380,134,161.1	171,299,943.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	380,134,161.1	171,299,943.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	380,134,161.1	171,299,943.3
118004	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	380,134,161.1	171,299,943.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,450.7	-
120	Нийтлэг татварын бус орлого	62,450.7	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,450.7	-
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,450.7	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	226,481,337.8	13,042.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	226,481,337.8	13,042.7
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	385,937.8	13,042.7
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	226,095,400.0	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>531,521,427.6</u>	<u>263,648,299.8</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,521,427.6	263,648,299.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	243.0	8.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	243.0	8.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	243.0	8.0
211	ХҮҮ	67,290,044.6	44,806,671.8
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	67,290,044.6	44,806,671.8
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	67,290,044.6	44,806,671.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	464,231,140.0	218,841,620.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	463,861,920.0	218,841,620.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	451,821,720.0	218,841,620.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,040,200.0	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	369,220.0	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	369,220.0	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>75,156,522.0</u>	<u>(92,335,313.8)</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	17,520,000.0	39,982,868.2
140002	Улсын төсвөөс олгосон зээл	17,520,000.0	39,982,868.2
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,334,691.8	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,334,691.8	-

2200	Дотоод эх үүсвэрээр	3,334,691.8	-
220001	Барилга байгууламж	3,334,691.8	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>14,185,308.2</u>	<u>39,982,868.2</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	169,832,770.1	197,762,631.2
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	169,832,770.1	197,762,631.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	17,520,000.0	231,648,428.2
230001	Эргэж төлөгдөх зээл	17,520,000.0	231,648,428.2
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	190,422,785.5	(1,430,939.6)
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	252,985.5	(1,430,939.6)
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	190,169,800.0	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(38,110,015.4)</u>	<u>(32,454,857.4)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	51,231,814.8	(84,807,303.0)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,575,488.2	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,807,303.0	

3.4 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	ХУВЬ
		БАТЛАГДСАН ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		84,807,303.0		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	283,866,964.3	278,596,720.5	5,270,243.8	98.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	283,866,964.3	278,596,720.5	5,270,243.8	98.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	8.0	(8.0)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8.0	(8.0)	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		8.0	(8.0)	
211	ХҮҮ	60,666,964.3	59,768,135.2	898,829.1	98.52
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	60,666,964.3	59,768,135.2	898,829.1	98.52
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	60,666,964.3	59,768,135.2	898,829.1	98.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,200,000.0	218,828,577.3	4,371,422.7	98.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	223,200,000.0	218,828,577.3	4,371,422.7	98.04
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	223,200,000.0	218,828,577.3	4,371,422.7	98.04
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ			-	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	283,866,964.3	193,789,417.5	90,077,546.8	68.27
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	283,866,964.3	193,789,417.5	90,077,546.8	68.27
131001	Улсын төсвөөс санхүүжих	283,866,964.3	193,789,417.5	90,077,546.8	68.27